



**МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ**

2016 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А-6

Улаанбаатар хот

Дүрэм, журам шинэчлэн батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.“Монголбанкны Улсын байцаагчийн дүрэм”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Монголбанкны Улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа, онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталж, 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2.Энэ тушаал гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны А-111, А-113 дугаар тушаалыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (Х.Дэлгэр)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ

14 0060

Tushaal 2016.doc

Монголбанкны Ерөнхийлөгчийн
2016 оны 01 дүгээр сарын 29 ны өдрийн
А.х. дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



МОНГОЛБАНКНЫ УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Монголбанкны Улсын байцаагч (цаашид "Улсын байцаагч" гэх)-ийн эрх зүйн байдал, түүний үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлж, Улсын байцаагч банк, санхүүгийн зах зээлийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Монголбанкнаас батлан гаргасан дүрэм, журам, заавар, Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийг банк, хуулийн этгээд, түүний эрхэлж буй ажил үйлчилгээнд хамаарах ажилтан хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү дүрэм нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, "Монголбанкны хөдөлмөрийн дотоод журам" болон тэдгээртэй холбогдон гаргасан хууль тогтоомж, эрх зүйн бусад акттай нийцсэн байна.

ХОЁР. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэхүү дүрэмд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1. "хяналт шалгалт" гэж банк, санхүүгийн зах зээлийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Монголбанкнаас батлан гаргасан дүрэм, журам, заавар, Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийг хуулийн этгээд, түүний эрхэлж буй ажил үйлчилгээнд хамаарах ажилтан хэрхэн биелүүлж байгааг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах цогц арга хэмжээг;

2.1.2. "акт" гэж хяналт шалгалтын чиг үүргийн хүрээнд аливаа үйл ажиллагаа, бодит байдлын үнэн зөвийг шалган, үндсэн баримтаар нотолгоо дүгнэлт гаргаж, зохих журмын дагуу албажуулсан баримт бичгийг;

2.1.3. "мэдэгдэл" гэж хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах, тайлбар мэдээлэл авах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой шаардлага тавьсан, эсхүл шаардлагатай бол хугацаа зааж гаргасан баримт бичгийг;

2.1.4. "шийтгэвэр" гэж хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил гаргасан ажилтан, хуулийн этгээд, банкинд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ногдуулсан шийдвэрийг.

ГУРАВ. Улсын байцаагчийн үйл ажиллагааны үндсэн зарчим

3.1. Улсын байцаагч нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.

3.1.1.Хууль дээдлэх, шударга ёсыг эрхэмлэх, бодитой байх, хөндлөнгийн нөлөөнд үл автах, шалгуулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх, ёс зүйтэй байх;

3.1.2.Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хууль тогтоомжийн хүрээнд хамгаалах;

3.1.3.Улсын байцаагч нь өөрт холбогдох ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй асуудлыг хянан шалгаж, шийдвэрлэхээс татгалзах.

3.2.Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч болон хяналт шалгалтын чиглэлийн эрх бүхий нэгжийн удирдлагын баталсан удирдамж, томилолтоор Улсын байцаагчийн хяналт шалгалтын хүрээ, зорилго, чиглэл тодорхойлогдоно.

ДӨРӨВ. Улсын байцаагчийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг

4.1.Улсын байцаагч нь банк, санхүүгийн зах зээлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж болон бусад эрх зүйн акт, Монголбанкнаас батлан гаргасан дүрэм, журам, заавар, Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийг банк, хуулийн этгээд, түүний эрхэлж буй ажил үйлчилгээнд хамаарах ажилтан хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, шалгалт хийх;

4.2.Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах, тайлбар мэдээлэл авах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар ажилтан, хуулийн этгээд, банкинд тодорхой шаардлага тавьж, хугацаатай үүрэг, даалгавар өгч биелэлтийг хангуулах;

4.3.Шалгуулагч банк, хуулийн этгээд, түүний эрхэлж буй ажил үйлчилгээнд хамаарах ажилтантай холбогдсон өргөдөл, гомдлыг шалгаж, шийдвэрлэх;

4.4.Улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч болон хяналт шалгалтын чиглэлийн эрх бүхий нэгжийн удирдлагын баталсан удирдамж, томилолтын дагуу хяналт тавих, шалгалт хийх;

4.5. Шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалтын чиг үүрэг бүхий нэгжийн удирдлагын баталсан удирдамж, томилолтын дагуу Улсын байцаагч нь хэсэгчилсэн шалгалт хийх.

ТАВ. Улсын байцаагчийн эрх зүйн байдал

5.1.Монголбанк нь Улсын ерөнхий байцаагч, Улсын ахлах байцаагч, Улсын байцаагчтай байх бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч нь Улсын ерөнхий байцаагч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нар Улсын ахлах байцаагч байна.

5.2.Монголбанкны Захирлуудын зөвлөлийн гишүүд, Санхүүгийн мэдээллийн албаны дарга, хяналт шалгалтын чиг үүрэг бүхий Хяналт шалгалтын газрын хэлтсийн захирал, Дотоод хяналт үйл ажиллагааны эрсдэлийн газрын хэлтсийн захирал, Валют, эдийн засгийн газрын хэлтсийн захирал, орон нутаг дахь Монголбанкны хэлтэс, салбарын захирлууд нь Улсын байцаагчийн эрхтэй байх бөгөөд Улсын байцаагчийн бүрэн эрх нь тухайн албан тушаалыг хаших хугацаанд хадгалагдана.

5.3.Энэ дүрмийн 5.2 дахь заалтад зааснаас бусад Улсын байцаагчийн эрхтэй байх албан тушаалын жагсаалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.

5.4.Улсын байцаагч нь энэхүү дүрмийн хавсралтаар батлагдсан, Улсын ерөнхий байцаагчаас олгосон үнэмлэх, дугаар бүхий тэмдэг болон акт, мэдэгдэл, шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

ЗУРГАА. Улсын байцаагчид тавигдах шаардлага

6.1. Улсын байцаагч нь дараах шаардлагыг хангасан байна.

6.1.1.Монголбанкны болон банкны ажилтны ёс зүйн дүрэм, хэм хэмжээг чанд баримталдаг;

6.1.2.Хяналт шалгалт хийхэд шаардагдах эдийн засагч, санхүүч, нягтлан бодогч, эрх зүйч, програм зохиогч буюу мэдээллийн технологийн мэргэжилтэй, бакалавраас доошгүй зэрэгтэй;

6.1.3.Банк, санхүүгийн байгууллагад энэхүү журмын 6.1.2 дахь заалтад заасан мэргэжлээр 2 (хоёр)-оос доошгүй жил ажилласан туршлагатай;

6.1.4.Монголбанкны хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч нэгжид хяналт шалгалтын мэргэжилтнээр 2 (хоёр)-оос доошгүй жил ажилласан;

6.1.5.Банк, санхүүгийн байгууллагад аливаа төрлийн хугацаа хэтэрсэн, чанаргүй өр төлбөргүй;

6.1.6.Ял шийтгэлгүй;

6.1.7.Улсын байцаагчийн эрх авах мэргэжил, ур чадварын түвшин тогтоох шалгалтад тэнцсэн;

6.2.Энэхүү дүрмийн 6.1.4, 6.1.7 дахь заалт нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Улсын байцаагчийн эрх шууд олгогдох албан тушаалтан болон орон нутаг дахь Монголбанкны хэлтэс, салбарын ажилтнуудад үл хамаарна.

6.3.Улсын байцаагчид тавигдах шаардлагыг хангасан эсэхийг Улсын байцаагчийн зөвлөл үнэлж дүгнэн, зохих шийдвэр гаргана.

ДОЛОО. Улсын байцаагчийн эрх, үүрэг

7.1. Улсын ерөнхий байцаагч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

7.1.1.Монголбанкны Улсын байцаагчийн зөвлөлийг тэргүүлэх, Улсын байцаагчийн эрх олгох, түдгэлзүүлэх, дуусгавар болгох болон Улсын байцаагчийн үйл ажиллагаатай холбоотой бусад шийдвэр гаргах;

7.1.2.Шалгагдах банк, хуулийн этгээдэд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг батлах, тэдгээрийн эрхэлж буй ажил үйлчилгээнд хамаарах иргэний үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын удирдамжийг батлах;

7.1.3.Улсын байцаагчийн эрх олгох шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг Улсын байцаагчийн зөвлөлийн саналыг үндэслэн томилох;

7.1.4.Улсын байцаагчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, бололцоогоор хангах;

7.1.5.Улсын байцаагчийн мэдлэг, боловсрол, мэргэжил болон мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах;

7.1.6.Хууль, тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

7.2.Улсын ахлах байцаагч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

7.2.1.Улсын байцаагчийн үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэлд хяналт тавих;

7.2.2.Шаардлагатай тохиолдолд удирдамжид заасны дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаанд биечлэн оролцох;

7.2.3.Энэ дүрэмд заасан Улсын байцаагчийн бүрэн эрх, үүрэг.

7.3.Улсын байцаагч нь холбогдох хууль тогтоомжид заасан эрх, үүргээс гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

7.3.1.Банк, санхүүгийн хууль тогтоомж, Монголбанкнаас батлан гаргасан дүрэм, журам, заавар, Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийн биелэлтэд батлагдсан удирдамж, томилолтын дагуу хяналт, шалгалт хийх, хуульд заасан арга хэмжээ авч хэрэгжүүлэх, захиргааны шийтгэл ногдуулах, хэрэгжилтийг хянах, үр дүнг хангуулах;

7.3.2.Улсын байцаагчийн үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон акт, мэдэгдэл, шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэглэх;

7.3.3.Хяналт шалгалтын явцад шаардлагатай асуудлыг магадлах, тодорхой мэргэжил, мэргэшлийн дэмжлэг авах, дүгнэлт гаргуулах зорилгоор Улсын байцаагчийн зөвлөлд хандаж, хяналт шалгалтын ажилд бусад газар (хэлтэс), орон нутаг дахь Монголбанкны хэлтэс, салбар, төлөөлөгчийн газрын ажилтныг татан оролцуулах, эрх бүхий байгууллагаар шаардлагатай гэж үзвэл зохих нарийн мэргэшил шаардсан хөндлөнгийн шинжилгээг хийлгэх;

7.3.4.Шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалт хийх үедээ холбогдох эрх бүхий байгууллагаар хамгаалуулах тухай Улсын байцаагчийн зөвлөлд хандаж, шийдвэрлүүлэх;

7.3.5.Хяналт шалгалтад саад учруулсан, эсэргүүцсэн, доромжилсон этгээдийн талаар эрх бүхий байгууллагад хандаж зохих арга хэмжээг авахуулах;

7.3.6.Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбогдсон санал, гомдлыг Улсын байцаагчийн зөвлөлөөр хэлэлцүүлэх;

7.3.7.Хяналт шалгалтыг хууль тогтоомжийн хүрээнд, цаг хугацаанд нь бүрэн гүйцэд, мэргэжлийн түвшинд чанартай хийж гүйцэтгэх;

7.3.8.Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг таслан зогсоох, тэдгээрийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар шалгагдаж байгаа байгууллага, эрх бүхий этгээдэд шаардлага тавих, хугацаатай үүрэг даалгавар өгөх, хэрэгжилтийг хянах, үр дүнг хангуулах арга хэмжээ авах;

7.3.9.Банкны тухай хууль тогтоомж болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн бол тухайн зөрчлийн шинж байдлыг харгалзан албадлагын арга хэмжээ авах тухай санал дэвшүүлэх;

7.3.10.Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзвэл шалгалтын акт, холбогдох баримтыг Захирлуудын зөвлөл эсвэл Хяналт шалгалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

7.3.11.Хийсэн хяналт шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, акт, мэдэгдэл, шийтгэврийн үндэслэлийг гагцхүү өөрөө хариуцах;

7.3.12.Ногдуулсан арга хэмжээ, захиргааны шийтгэлийнхээ хэрэгжилтэд хяналт тавих;

7.3.13.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг тухай бүр гаргаж, холбогдох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх;

7.3.14.Хууль тогтоомжийн дагуу үндэслэл бүхий хийсэн хяналт шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, акт, мэдэгдэл, шийтгэврийн үр дагаврыг хариуцахгүй байх.

НАЙМ. Улсын байцаагчийн бүрэн эрхийн баталгаа

8.1.Улсын байцаагчийн бүрэн эрхийн баталгаа, түүнд олгох цалин хөлс, шагнал урамшил, тусламж, тэтгэмж, нөхөх олговрыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан холбогдох журмаар зохицуулна.

ЕС. Улсын байцаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

9.1.Улсын байцаагчид Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 29 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, “Монголбанкны хөдөлмөрийн дотоод журам”-д зааснаас гадна дор дурдсан үйл ажиллагааг хориглоно:

9.1.1.Хяналт шалгалтын явцад олж авсан банк, хуулийн этгээдтэй холбоотой мэдээллийг бусдад дамжуулах, тараах, гаргаж өгөх, хувийн зорилгоор ашиглах;

9.1.2.Хувийн ашиг сонирхлын үүднээс эрх мэдэл, албан тушаалаа хэтрүүлэх, урвуулан ашиглах;

9.1.3.Хийж буй болон хийгдсэн хяналт шалгалттай холбоотой аливаа мэдээ, мэдээллийг бусад болон олон нийтэд аливаа хэлбэрээр мэдээлэх, тараах;

9.1.4.Шалгалтын акт, материалыг бодит байдлаас санаатайгаар зөрүүтэй бичих, хяналт шалгалтын танилцуулга, дүгнэлтийг гуйвуулах;

9.1.5.Шалгалт хийх, танилцуулга, дүгнэлт бичих, арга хэмжээ авах, акт, мэдэгдэл үйлдэх, шийтгэвэр ногдуулахдаа бусдын нөлөөнд автах, авлига авах;

9.1.6.Улсын байцаагчийн үнэмлэх, акт, мэдэгдэл, шийтгэврийн хуудсыг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, устгах, хуурамчаар үйлдэх болон тэдгээрийг бусад этгээдэд ашиглах боломж олгох;

9.1.7.Банк, санхүүгийн байгууллагын хяналтын багцыг эзэмших, хөнгөлөлттэйгээр зээл авах, санхүүгийн бусад зуучлалын үйлчилгээ үзүүлэх, ийм нөхцөл бүхий аливаа ажил үйлчилгээнд хамруулахыг шаардах;

9.1.8.Улсын байцаагч нь бусад Улсын байцаагч нарт хийж байгаа хяналт шалгалттай холбогдуулан хүсэлт тавих, дарамт шахалт үзүүлэх, хөндлөнгөөс нөлөөлөх;

9.1.9.Улсын байцаагчийн эрх, үүргийн хүрээнээс гадуур зүйл шаардах;

9.1.10.Хууль тогтоомжоор хориглосон бусад.

АРАВ. Улсын байцаагчийн үйл ажиллагаанд тавих хяналт

10.1.Улсын байцаагчийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг орон тооны бус Улсын байцаагчийн зөвлөл хэрэгжүүлнэ. Улсын байцаагчийн зөвлөлийн ажиллах журмыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.

АРВАН НЭГ. Улсын байцаагчийн эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, дуусгавар болгох

11.1.Улсын байцаагчийн бүрэн эрхийг дараах тохиолдолд түдгэлзүүлнэ.

11.1.1.Хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллага шаардсан;

11.1.2.Улсын байцаагчид холбогдох гомдол, зөрчлийг Улсын байцаагчийн зөвлөлөөр хэлэлцээд шийдвэр гаргасан;

11.1.3.Улсын байцаагчийн бүрэн эрхийн хугацаанд 90 (ерэн) хоногоос дээш хугацаатай чөлөө авсан, сургалтад хамрагдсан, эмчлүүлэх, сувилуулах болсон бол мөн хугацаагаар;

11.1.4.Хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.

11.2. Улсын байцаагчийн эрх дараах тохиолдолд дуусгавар болно.

11.2.1.Бүрэн эрхийн хугацаа нь дууссан;

11.2.2.Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, “Монголбанкны хөдөлмөрийн дотоод журам”, “Монголбанкны ажилтны ёс зүйн дүрэм”-ийн холбогдох заалтыг зөрчсөн нь шалгалтаар тогтоогдсон;

11.2.3.Энэ дүрмийн 9 дүгээр зүйлийг зөрчсөн нь тогтоогдсон;

11.2.4.Өөр ажил, албан тушаалд томилогдсон, ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн;

11.2.5.Хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.

АРВАН ХОЁР. Улсын байцаагчаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ, ногдуулах захиргааны шийтгэл

12.1.Банк, санхүүгийн зах зээлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн банк, хуулийн этгээд, түүний эрхэлж буй ажил үйлчилгээнд хамаарах иргэнд Банкны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан дараах албадлагын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

12.1.1.Илэрсэн зөрчилд Улсын байцаагчийн акт тогтоох,

12.1.2.Илэрсэн зөрчлийг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлага тавих, мэдэгдэл хүргүүлэх,

12.1.3.Шаардлагатай тохиолдолд актаар тогтоогдсон зөрчлийн шинж байдал, үүссэн эрсдэл, учирсан хохирлын хэмжээнээс хамаарч буруутай этгээдэд шийтгэвэр ногдуулах.

12.2.Улсын байцаагчийн акт.

12.2.1.Улсын байцаагч шалгалт хийсэн үйл ажиллагааныхаа талаар танилцуулга, материал бичихийн зэрэгцээ, шаардлагатай тохиолдолд хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчилд Улсын байцаагчийн акт тогтооно.

12.2.2.Улсын байцаагчийн актад тухайн хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг гаргасан огноо, зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээд, банкны нэр, албан тушаал, илэрсэн зөрчлийн агуулга, зөрчсөн хууль тогтоомж, эрх зүйн актын заалтыг тус бүр тодорхой бичнэ.

12.2.3.Улсын байцаагч нь тогтоосон актаа зөрчил гаргасан этгээд, холбогдох албан тушаалтнуудад биечлэн танилцуулж, гарын үсэг зуруулна.

12.2.4.Зөрчил гаргасан этгээд Улсын байцаагчийн тогтоосон акт, хүргүүлсэн мэдэгдэл, ногдуулсан шийтгэврийг хүлээн авснаас хойш холбогдох хууль тогтоомжид тусгайлан заасан хугацаанд буюу 30 хоногийн дотор Улсын ерөнхий байцаагчид гомдол гаргаж болно.

12.2.5.Зөрчил гаргасан этгээд Улсын байцаагчийн тогтоосон акт, мэдэгдэл, шийтгэвэрт тайлбар, гомдол гаргах нь уг акт, мэдэгдэл, шийтгэврийг хүчингүйд тооцох, эс биелүүлэх үндэслэл болохгүй.

12.2.6.Хяналт шалгалтын цар хүрээ, хугацаа, тухайн нөхцөл байдал, шаардлагын дагуу шалгалт бүрэн дуусахаас өмнө эсхүл шалгалтын танилцуулга материал бичихгүйгээр Улсын байцаагчийн акт тогтоож болно.

12.2.7.Улсын байцаагчийн акт нь хүчин төгөлдөр болсон хугацаанаас эхлэн тухайн зөрчилтэй холбогдсон асуудлыг шийдвэрлэх, түүнд ногдуулах арга хэмжээ, захиргааны шийтгэл ногдуулах хууль зүйн үндэслэл болно.

12.3.Улсын байцаагчийн мэдэгдэл.

12.3.1.Улсын байцаагч нь хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор, хугацаатай үүрэг даалгавар өгөх зэрэг бүрэн эрхийн хүрээнд мэдэгдэл хүүргүүлнэ.

12.3.2.Улсын байцаагчийн мэдэгдэл нь зөвлөмж, анхааруулга, шаардлагын хэлбэр, утга санаа, агуулгатай, хэрэгжүүлэх нөхцөл, хариуцах эзэн, хугацааг тодорхой тусгасан байна.

12.3.3.Улсын байцаагчийн мэдэгдэлд илэрсэн зөрчлийг арилгах талаар өгсөн үүрэг даалгавар, хугацаа болон түүнийг тогтоосон хугацаанд эс биелүүлбэл авч хэрэгжүүлэх дараагийн арга хэмжээний талаар заана.

12.4.Шийтгэврийн хуудас.

12.4.1.Улсын байцаагч нь тогтоосон актаа үндэслэн холбогдох хууль тогтоомжид заасныг баримтлан шийтгэврээр торгууль ногдуулна.

12.4.2.Торгууль ногдуулахад хуульд заасан хэмжээг мөрдөнө.

12.4.3.Улсын байцаагч шийтгэвэр ногдуулахдаа зөрчил үүссэн шалтгаан, шинж байдал, агуулга, хэлбэр, хохирлын хэмжээ, зөрчил арилсан эсэх зэрэг хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан холбогдох хууль, тогтоомжийн дагуу бие даан шийдвэрлэнэ.

АРВАН ГУРАВ. Улсын байцаагчийн ногдуулсан арга хэмжээ, захиргааны шийтгэлийн хэрэгжилтийг хангах

13.1.Банкны байгууллагад ногдуулсан шийтгэврийг хуульд заасан хугацаанд төлөөгүй бол Улсын байцаагчийн ногдуулсан шийтгэврийг үндэслэн тухайн банкны Монголбанкн дахь харилцах данснаас үл маргах журмаар суугтан авч Улсын төсвийн орлогын дансанд шилжүүлнэ.

13.2.Энэ дүрмийн 13.2 дахь хэсэгт зааснаас бусад хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтан нь тогтоосон хугацаанд торгуулийг төлөөгүй бол Захиргааны хариуцлагын тухай хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу Улсын байцаагч шийдвэрлүүлж, холбогдон гарсан зардлыг хариуцлага хүлээсэн этгээдээр төлүүлнэ.

13.3.Улсын байцаагчийн зөвлөлөөс Улсын байцаагчийн тогтоосон акт, бичсэн мэдэгдэл, ногдуулсан арга хэмжээ, захиргааны шийтгэлийг өөрчилж шийдвэрлэсэн нь хууль тогтоомж зөрчсөн болохыг нотолсон тохиолдолд эдгээр акт, мэдэгдэл, ногдуулсан арга хэмжээ, захиргааны шийтгэлээс үүдэн гарах хариуцлага тухайн Улсын байцаагчид хамаарахгүй.

13.4.Улсын байцаагчийн тогтоосон акт, мэдэгдэл, шийтгэврийг шалгуулагч иргэн, хуулийн этгээд эс зөвшөөрөх нь Улсын байцаагчийн акт, мэдэгдэл, шийтгэврээр хүлээх хариуцлагаас чөлөөлөгдөх, биелүүлэхээс татгалзах үндэслэл болохгүй.

АРВАН ДӨРӨВ. Улсын байцаагч хэвлэмэл хуудас, хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэх, эргүүлэн тушаах

14.1.Тамгын газар Улсын байцаагчийн эрх олгогдсон ажилтанд шийдвэр гарснаас хойш ажлын 5 (тав) хоногийн дотор Улсын байцаагчийн үнэмлэх, шийтгэврийн хэвлэмэл хуудас, хувийн дугаар бүхий тэмдгийг олгоно.

14.2.Улсын байцаагч нь үрэгдүүлсэн үнэмлэх, тэмдэг, шийтгэврийн хуудас, хэрэглэсэн болон залруулан бичсэн шийтгэврийн хуудас, акт, мэдэгдэл, шийтгэврийн тайланг энэхүү дүрмийн хавсралтын дагуу гаргаж, Тамгын газрын холбогдох ажилтанд дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан хүргүүлнэ.

14.3.Улсын байцаагчийн эрхийг түдгэлзүүлсэн, дуусгавар болгосон бол энэ тухай мэдэгдлийг холбогдох ажилтанд Тамгын газар ажлын 3 (гурав) хоногийн дотор мэдэгдэнэ. Мэдэгдэл хүлээн авсан ажилтан ажлын 3 (гурав) хоногийн дотор Улсын байцаагчийн үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг, хэрэглэгдсэн шийтгэврийн хэвлэмэл хуудасны тайлан, хэрэглэгдээгүй үлдсэн хуудсыг Тамгын газар, харьяалах газар (хэлтэс, алба)-т актаар хүлээлгэн өгч, Улсын байцаагчтай холбогдох тооцоог дуусгавар болгоно.

АРВАН ТАВ. Улсын байцаагчид хүлээлгэх хариуцлага

15.1.Энэ дүрмийг зөрчсөн Улсын байцаагчид Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу Улсын ерөнхий байцаагч хариуцлага хүлээлгэнэ.

_____оОо_____

МОНГОЛБАНКНЫ УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ, АХЛАХ БАЙЦААГЧ,
БАЙЦААГЧИЙН ҮНЭМЛЭХНИЙ ЗАГВАР

<p>Дугаар...овогтойнь МОНГОЛБАНКНЫ УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ тул үнэмлэх олгов.</p> <p>БАЙНГЫН ХУЧИНТЭЙ.</p>	<p>Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу банк, банктay холбогдсон иргэн, хуулийн этгээд аж ахуйн нэгж, байгууллагын мөнгө, эзэл, санхүүгийн холбогдолтой баримт, материалыг шалгах эрхтэй бөгөөд Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 24, 25-р зүйлд заасан бүрэн эрхтэй болно.</p> <p>Монгол Улсын Их Хурлын дарга _____ ҮНЭМЛЭХИЙГ БУСДАД ШИЛЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОНО.</p>
<p>Дугаар...овогтойнь МОНГОЛБАНКНЫ УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ тул шалгах эрхийн үнэмлэх олгов.</p> <p>БАЙНГЫН ХУЧИНТЭЙ.</p>	<p>Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу банк, банктay холбогдсон иргэн, хуулийн этгээд аж ахуйн нэгж, байгууллагын мөнгө, эзэл, санхүүгийн холбогдолтой баримт, материалыг шалгах эрхтэй бөгөөд Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 25-р зүйлд заасан бүрэн эрхтэй болно.</p> <p>Монголбанкны Ерөнхийлөгч Улсын Ерөнхий байцаагч _____ ҮНЭМЛЭХИЙГ БУСДАД ШИЛЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОНО</p>
<p>Дугаар...овогтойнь МОНГОЛБАНКНЫ УЛСЫН БАЙЦААГЧ тул шалгах эрхийн үнэмлэх олгов.</p> <p>БАЙНГЫН ХУЧИНТЭЙ.</p>	<p>Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу банк, банктay холбогдсон иргэн, хуулийн этгээд аж ахуйн нэгж, байгууллагын мөнгө, эзэл, санхүүгийн холбогдолтой баримт, материалыг шалгах эрхтэй бөгөөд төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 25-р зүйлд заасан бүрэн эрхтэй болно.</p> <p>Монголбанкны Ерөнхийлөгч Улсын Ерөнхий байцаагч _____ ҮНЭМЛЭХИЙГ БУСДАД ШИЛЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОНО</p>

МОНГОЛБАНКНЫ УЛСЫН БАЙЦААГЧИЙН ТЭМДГИЙН ЗАГВАР



УЛСЫН БАЙЦААГЧИЙН АКТЫН ЗАГВАР



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

УЛСЫН БАЙЦААГЧИЙН АКТ

... оны ... дүгээр/дугаар сарын ...-ны/ний өдөр Дугаар:он/Улсын байцаагчийн тэмдгийн дугаар/№ Улаанбаатар хот

АКТ ТОГТООСОН:

МОНГОЛБАНКНЫ ХЯНАН ШАЛГАГЧ,
УЛСЫН БАЙЦААГЧ _____ (Улсын байцаагч, хянан шалгагчийн нэр, тэмдэг)
(гарын үсэг)

АКТТАЙ ТАНИЛЦСАН:

_____ БАНКНЫ
(албан тушаалын нэр) _____ (албан тушаалтны нэр, тэмдэг)
(гарын үсэг)

12.2.3. Улсын байцаагч нь тогтоосон актаа зөрчил гаргасан этгээд, холбогдох албан тушаалтнуудад биечлэн танилцуулж, гарын үсэг зуруулна.

12.2.4. Зөрчил гаргасан этгээд Улсын байцаагчийн тогтоосон акт, хүргүүлсэн мэдэгдэл, ногдуулсан шийтгэврийг хүлээн авснаас хойш холбогдох хууль тогтоомжид тусгайлан заасан хугацаанд буюу 30 хоногийн дотор Улсын ерөнхий байцаагчид гомдол гаргаж болно.

УЛСЫН БАЙЦААГЧИЙН МЭДЭГДЛИЙН ЗАГВАР



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

УЛСЫН БАЙЦААГЧИЙН МЭДЭГДЭЛ

... оны ... дүгээр/дугаар сарын ...-ны/ний өдөр Дугаар:он/Улсын байцаагчийн тэмдгийн дугаар/№ Улаанбаатар хот

МЭДЭГДЭЛ БИЧСЭН:

МОНГОЛБАНКНЫ ХЯНАН ШАЛГАГЧ,
УЛСЫН БАЙЦААГЧ _____ (Улсын байцаагч, хянан шалгагчийн нэр, тэмдэг)
(гарын үсэг)

ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН АВСАН:

_____ БАНКНЫ
(албан тушаалын нэр) _____ (албан тушаалтны нэр, тэмдэг)
(гарын үсэг)

ШИЙТГЭВРИЙН ЗАГВАР



ШИЙТГЭВЭР

... оны ... сарын ... өдөр

№

..... хот /аймаг/

..... /хуулийн этгээдийн нэр/ ажилтан

..... овог /эцэг, эхийн нэр/ нь

.....
/зөрчсөн хууль тогтоомжийн зүйл, заалт/

.....
/зөрчлийн утга/

зөрчсөн

тул

.....
/торгох хууль тогтоомжийн зүйл, заалт/

үндэслэн төгрөгөөр торгов.

Шийтгэврээр ногдуулсан торгуулийн төгрөгийг ажлын 3 /гурав/ хоногийн дотор Монголбанкн дахь Улсын төсвийн орлогын.....тоот дансанд оруулах үүрэгтэй.

Тогтоосон хугацаанд торгуулийг төлөөгүй тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэнэ.

Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл холбогдох хууль тогтоомжид тусгайлан заасан хугацаанд буюу 30 хоногийн дотор Улсын ерөнхий байцаагчид гомдол гаргаж болно.

МОНГОЛБАНКНЫ УЛСЫН БАЙЦААГЧ:

ЗӨРЧИЛ ГАРГАСАН:

“Монголбанкны Улсын байцаагчийн дүрэм”-ийн Хавсралт 6

МОНГОЛБАНКНЫ УЛСЫН БАЙЦААГЧИЙН ХЭВЛЭМЭЛ ХУУДАС
ХЭРЭГЛЭСЭН ТАЙЛАН

Улсын байцаагчийн нэр: _____

Улсын байцаагчийн тэмдгийн хувийн дугаар: _____

...он ... сар ...өдөр

дд	Тайлант хугацаанд тогтоосон актын тоо /дугаарын хамт/	Тайлант хугацаанд бичсэн мэдэгдлийн тоо /дугаарын хамт/	Тайлант хугацаанд бичсэн шийтгэврийн тоо /дугаарын хамт/

1.1.Акт

дд	Актын дугаар	Эрх зүйн зөрчил илэрсэн огноо	Зөрчил гаргасан субъект	Зөрчил гаргасан субъекийн эрхэлж буй ажил үйлчилгээ	Илэрсэн зөрчлийн агуулга	Зөрчсөн хууль тогтоомжийн заалт	Зөрчлийн дүн

1.2.Мэдэгдэл

дд	Мэдэгдлийн дугаар	Илэрсэн зөрчил	Хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллах талаар өгсөн даалгавар, биелүүлэх хугацаа	Тогтоосон хугацаанд эс биелүүлбэл авах арга хэмжээ, түүний хэрэгжилт

1.3.Шийтгэврийн хуудас

дд	Үндэслэсэн актын дугаар	Шийтгэврийн хуудасны дугаар	Зөрчил илэрсэн огноо	Зөрчилд хамаарах шийдвэр гаргасан этгээд	Зөрчил илрэх үед тогтоогдсон нөхцөл байдал	Торгууль ногдуулах хууль тогтоомжийн заалт	Ногдуулсан торгуулийн хэмжээ, биелэлт	Хэрэгжилт

Тайлан гаргасан:

Улсын байцаагч (Нэр, гарын үсэг, тэмдэг)

МОНГОЛБАНКНЫ УЛСЫН БАЙЦААГЧИЙН ҮРЭГДҮҮЛСЭН
ХЭВЛЭМЭЛ ХУУДАС, ТЭМДЭГ, ҮНЭМЛЭХИЙН ТАЙЛАН

Улсын байцаагчийн нэр: _____

Улсын байцаагчийн тэмдгийн хувийн дугаар: _____

Улсын байцаагчийн үнэмлэхийн дугаар: _____

Үрэгдүүлсэн огноо: _____

Бичсэн хэвлэмэл хуудаст хамаарах:

дд	Актын тоо /дугаарын хамт/	Мэдэгдлийн тоо /дугаарын хамт/	Торгуулийн хуудасны тоо /дугаарын хамт/	Шийтгэврийн тоо /дугаарын хамт/

Шинэ /бичээгүй/ хэвлэмэл хуудаст хамаарах:

Үрэгдүүлсэн нөхцөл байдлын тухай тайлбар: _____

Тайлан гаргасан:

Улсын байцаагч (Нэр, гарын үсэг, тэмдэг)

МОНГОЛБАНКНЫ УЛСЫН БАЙЦААГЧ АКТ, МЭДЭГДЭЛ,
ШИЙТГЭВРИЙГ ЗАЛРУУЛАН БИЧСЭН ТУХАЙ ТАЙЛАН

Улсын байцаагчийн нэр: _____

Улсын байцаагчийн тэмдгийн хувийн дугаар: _____

Улсын байцаагчийн үнэмлэхийн дугаар: _____

Огноо: _____

Дд	Тайлант хугацаанд залруулан бичсэн актын тоо /дугаарын хамт/	Тайлант хугацаанд залруулан бичсэн мэдэгдлийн тоо /дугаарын хамт/	Тайлант хугацаанд залруулсан бичсэн торгууль хуудасны тоо /дугаарын хамт/	Тайлант хугацаанд залруулан бичсэн шийтгэврийн тоо /дугаарын хамт/

Акт

дд	Залруулан бичсэн актын дугаар, огноо	Дахин бичсэн актын дугаар, огноо	Залруулан бичих болсон тухай тайлбар
Нийт залруулан бичсэн актын тоо:			

Мэдэгдэл

дд	Залруулан бичсэн мэдэгдлийн дугаар, огноо	Дахин бичсэн мэдэгдлийн дугаар, огноо	Залруулан бичих болсон тухай тайлбар

Шийтгэврийн хуудас

дд	Залруулан бичсэн шийтгэврийн хуудасны дугаар, огноо	Дахин бичсэн шийтгэврийн хуудасны дугаар, огноо	Залруулан бичих болсон тухай тайлбар
Нийт залруулан бичсэн шийтгэврийн хуудасны тоо:			

Тайлан гаргасан:

Улсын байцаагч (Нэр, гарын үсэг, тэмдэг)

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016
оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн
А... дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



МОНГОЛБАНКНЫ УЛСЫН БАЙЦААГЧИЙН БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАТАЛГАА, ОНЦГОЙ НӨХЦӨЛИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монголбанкны Улсын байцаагч (цаашид “Улсын байцаагч” гэх)-ийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ аливаа этгээдээс хараат бус байх, үүрэгт ажлаа үр дүнтэй, тасралтгүй гүйцэтгэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эдийн засаг, нийгмийн баталгаагаар хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, “Монголбанкны хөдөлмөрийн дотоод журам”, “Монголбанкны Улсын байцаагчийн дүрэм”, “Монголбанкны ажилтанд тусламж, тэтгэмж, нөхөн олговор олгох журам” болон тэдгээртэй холбогдон гаргасан хууль тогтоомж, эрх зүйн бусад акттай нийцсэн байна.

ХОЁР. Улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа, онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох

2.1. Улсын байцаагч нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, “Монголбанкны хөдөлмөрийн дотоод журам”, “Монголбанкны ажилтанд тусламж, тэтгэмж, нөхөн олговор олгох журам”-д заасан Монголбанкны ажилтнуудын ажиллах нөхцөл, баталгаа, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшуулал, тэтгэвэр, тэтгэмжээс гадна дор дурдсан нэмэгдэл баталгаагаар хангагдана.

2.2. Улсын байцаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдэл:

2.2.1. Улсын байцаагчид тухайн албан тушаалыг хаших хугацаанд албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг Монголбанкны Улсын ерөнхий байцаагч тогтооно.

2.2.2. Улсын ерөнхий болон ахлах байцаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийг тухайн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиар тооцож олгоно.

2.2.3. Монголбанкны Захирлуудын зөвлөлийн гишүүд, Санхүүгийн мэдээллийн албаны дарга, хяналт шалгалтын чиг үүрэг бүхий Хяналт шалгалтын газрын хэлтсийн захирал, Дотоод хяналт үйл ажиллагааны эрсдэлийн газрын хэлтсийн захирал, Валют, эдийн засгийн газрын хэлтсийн захирал, орон нутаг дахь Монголбанкны салбар, хэлтсийн захирлын Улсын байцаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийг тухайн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиар тооцож олгоно.

2.2.4. Улсын байцаагчаар ажиллаж буй ажилтанд онцгой нөхцөлийн нэмэгдлийг тухайн албан тушаалын сарын үндсэн цалингийн 30 хувиар тооцож олгоно.

Tushaal 2016.doc

2.2.5.Улсын байцаагчаар 5 жилээс дээш ажилласан ажилтанд онцгой нөхцөлийн нэмэгдлийг тухайн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хүртэл хувиар, 15 жилээс дээш ажилласан ажилтанд тухайн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хүртэл хувиар тооцож олгох асуудлыг харьяалах газар, алба, орон нутаг дахь Монголбанкны хэлтэс, салбарын захирлын санал, тодорхойлолт гаргасан нөхцөлд Улсын байцаагчийн зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.2.6.Улсын байцаагчаар 20-иос дээш жил тогтвортой ажилласан ажилтанд онцгой нөхцөлийн нэмэгдлийг тухайн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиар тооцож олгоно.

2.2.7.Хяналт шалгалт хийх бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хот, суурингийн доторх нийтийн тээврийн хэрэгсэл (таксинаас бусад)-ээр зорчиход зориулж сар бүр тогтмол унааны зардлын санхүүжилт олгоно.

2.3.Улсын байцаагчийн нийгмийн бусад баталгаа.

2.3.1.Хяналт шалгалт хийх бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан гүтгэсэн, доромжилсон, дарамталсан, амь нас, эрүүл мэндэд нь бодит аюул заналхийлсэн бол Монголбанк холбогдох эрх бүхий байгууллагад хандаж, шаардлагатай арга хэмжээг авах;

2.3.2.Улсын байцаагчийн зөвлөлийн баталсан хөтөлбөрийн дагуу жил тутам нэг удаа зохион байгуулагдах Улсын байцаагч нарт зориулсан тусгай сургалтад хамрагдах;

2.3.3.Улсын байцаагч тусгай сургалтад хамрагдах хугацаанд түүнд цалин хөлс нэмэгдлийг хэвээр олгох;

2.3.4.Улсын байцаагч хяналт шалгалтаар явах үедээ шаардлагатай тохиолдолд албаны унаагаар үйлчлүүлнэ.

ГУРАВ.Бусад

3.1.Энэ журамд заасан онцгой нөхцөлийн нэмэгдлийг хүссэн Улсын байцаагч Тамгын газарт холбогдох материалыг хавсаргасан өргөдөл гаргана. Өргөдөлд Улсын байцаагчийн хийж гүйцэтгэсэн ажлын тайлан (банк, санхүүгийн байгууллагад шалгалтаар оролцсон байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тогтоосон акт, мэдэгдэл, шийтгэвэр зэргийн талаар тусгах)-г харьяалах газрын захирлын санал, дүгнэлтийн хамт хүргүүлнэ.

3.2.Тамгын газар өргөдөл хүсэлтийг нэгтгэн улиралд нэг удаа Улсын байцаагчийн зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

3.3.Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

_____оОо_____